

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийг үндэслэн Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. “Ногдол ашгийн хуваарилалтад хяналт тавих тухай” журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолыг олон нийтэд сурталчлан, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГҮНДЭНБАЛ

ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШИГ
ХУВААРИЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ
ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Хувьцаат компанийн эрх бүхий байгууллагаас ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувь нийлүүлэгчдэд мэдээлэх, ногдол ашгийг тараах, тайлагнах асуудалд хяналт тавихад энэхүү журмыг баримтална.

ХОЁР. Ногдол ашиг хуваарилах шийдвэр
гаргах, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх

2.1. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд ногдол ашиг хуваарилах талаархи заалтад нийцсэн шийдвэрийг компанийн эрх бүхий байгууллага гаргана.

Хэрэв Компанийн дүрэмд энэ тухай тусгайлан заагаагүй бол ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргахдаа “Компанийн тухай” хуулийн 47.3, 48 дугаар зүйлд заасан нөхцлийг баримтална.

Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт тухайн төрлийн нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ, ногдол ашгийг олгож эхлэх огноо, ямар хэлбэрээр олгох /бэлэн мөнгө, эд хөрөнгө, үнэт цаас зэрэг/ болон хэрхэн тараах /компани өөрөө болон эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулах/ зэргийг тусгасан байна.

2.2. Ногдол ашиг авах эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэх өдөр нь тухайн тайлангийн жилийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэх өдөр байна.

2.3. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргасан тохиолдолд уг шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд танилцуулна.

2.4. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал хуралдсанаас хойш 7 хоногоос илүүгүй байхаар тооцож ногдол ашиг тараах хугацааг тогтооно.

2.5. Ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэдэг журмаар олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр хувь нийлүүлэгчдэд хүргэнэ.

Уг мэдээлэлд тухайн төрлийн нэгж хувьцаанд ногдуулан хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийн хэмжээ, ногдол ашгийн төлбөрийг ямар хэлбэрээр хийх, ногдол ашгийг тарааж эхлэх огноо, компани өөрөө эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан тараах алин болох, мэргэжлийн зуучлагч байгууллагын нэр, хаяг, ногдол

ашиг тараах байгууллагын ажиллах цагийн хуваарь, ногдол ашгийн талаар лавлагаа авах утасны дугаар зэргийг тусгасан байна.

2.6. Хувьцаа эзэмшигч нь арилжааны банкинд байгаа өөрийн харилцах болон хадгаламжийн дансанд ногдол ашгийг шилжүүлж авах талаар бичгээр хүсэлт гаргаж, холбогдох мэдээллийг өгсөн тохиолдолд ногдол ашгийн уг мөнгийг дансанд нь шилжүүлж болно.

2.7. 2.5-д заасан мэдээллийн хувийг хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын материалын хамт Үнэт цаасны хороонд /цаашид “Хороо” гэх/ ирүүлнэ.

ГУРАВ. Ногдол ашгийн талаар тайлан гаргах

3.1. Ногдол ашиг хуваарилалтын тайланг энэ журмын хавсралт /маягт А1- 16/-аар гаргаж жилийн санхүүгийн тайлангийн хамт 3 дугаар сарын 1-ний дотор Хороонд ирүүлнэ.

3.2. Компанийн тухай хуулийн 48.4-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд ногдол ашгийг шилжүүлсэн эсхүл төлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор мөн зүйлд заасан мэдэгдлийг зээлдүүлэгчдэд хүргэнэ.

ДӨРӨВ. Хариуцлага тооцох

4.1. Ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Компанийн хуулийн 47.6-д заасны дагуу алданги төлнө.

4.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчаас хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 38 дугаар зүйлд заасан захиргааны шийтгэл ногдуулна.

ҮНЭТ ЦААСНЫ ХОРОО

.....ХК-ийн хувьцааны ОНЫ
 НОГДОЛ АШГИЙН ТАЙЛАН

№	Тухайн төрлийн хувьцааны тоо	Нэгж хувьцаанд оногдуулан хуваарилсан ногдол ашгийн хэмжээ	Ногдол ашгийн нийт дүн	Ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан эрх бүхий байгууллагын нэр, шийдвэрийн огноо	Ногдол ашгийг тарааж эхлэхээр шийэрлэсэн огноо	Олгож эхэлсэн огноо	Ногдол ашгийг хаана олгох		Ногдол ашиг олгосон тухай тайлан				
							Компани дээр	Мэргэжлийн зуучлагч байгууллагаар	Жинхэнэ олгосон	Олгогдоогүй ногдол ашгийн үлдэгдэл		Хувьцаа эзэмшигч дийн тоо	
										Компанид	Зуучлагч байгууллагад	Ногдол ашиг авсан	Ногдол ашиг аваагүй
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13

Захирал.....

ХК-ийн ерөнхий нягтлан бодогч.....